



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/28

Амардалай

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 26 ны өдрийн хуралдааны шийдвэр, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26 ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Улс, хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 02-р сарын 27 ны өдрийн 08.00 цагаас 2020 оны 03-р сарын 03 ны өдрийг 06.00 цаг хүртэл сунган, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч ажиллахыг сумын багийн Засаг дарга нар болон Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/, хэсгийн цагдаа /Б.Насанжаргал/ нарт даалгасугай.

Хоёр: Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэх, бэлэн байдлыг хангах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нэмэлт нөөц бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /О.Балжинням/-д үүрэг болгосугай.

Гурав: Коронавирусын халдварын тархалтын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, хүрэлцээг тогтвортой байлгах нөөц бүрдүүлэх, худалдан авагч иргэдэд өдөрт борлуулах хэмжээг тогтоон, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэх, дамлан худалдахаас сэргийлэх, дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00-15.00 цаг хүртэл ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

Дөрөв: Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сумын Онцгой комиссын мэдэлд 1 тн шатахууны нөөц бүрдүүлж, иргэдэд хэмжээ тогтоож олгохыг "Дэлгэр-Алтанзагас" ХХК, "Зэт Би Эс Ди" ХХК-ны захирал нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ИШ-ЁНДОН

4880100066